

## **“БИЧИЛ УУРХАЙН ГАР ҮЙЛДВЭРЛЭГЧДИЙН ХОЛБОО” (CASM) ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГЫН “БИЧИЛ УУРХАЙ БА ХӨДӨӨГИЙН ХӨГЖИЛ” СЭДЭВТ ЧУУЛГАНД ОРОЛЦСОН АЖЛЫН ТАЙЛАН**

“Бичил уурхайн гар үйлдвэрлэгчдийн холбоо” (CASM) нь анх 1999 онд Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр, гар аргаар ашигт малтмал олборлогчдын талаар харилцан мэдээлэл солилцон, туршлага судлах зорилгоор байгуулагдсан олон улсын байгууллага юм.

CASM нь 2001 оноос жил бүр чуулганаа хуралдуулж энэ жил 9 дэх удаагийн чуулганаа Мозанбик улсын Мапуто, Шинмой хотуудад “бичил уурхай ба хөдөөгийн хөгжил” сэдэвтэйгээр зохион байгууллаа. 2007 онд 7 дугаар чуулганаа Монголд зохион байгуулж байсан юм байна.

Энэ чуулганд Монголоос 8 хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөл оролцсон ба энд УИХ-ын гишүүн Занданшатар, ЭБЭХЯамны Уул уурхай хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга Б.Батхүү, CASM-н удирдах зөвлөлийн гишүүн Ч.Энхзаяа, манай ТББ-аас миний бие Г.Батсайхан, Швецарийн хөгжлийн Агентлагаас хэрэгжүүлж байгаа Тогтвортой бичил уурхай төслийн зохицуулагч П.Үржинлхүндэв, төслийн ажилтан З.Золзаяа, эрдэмтэн судлаач Хулдорж, Түмэнбаяр нар байлаа

Чуулган 9 сарын 8-нд эхэлж CASM-ын дарга, Мозамбикийн эрдэс баялгийн сайд үг хэлж нээлт хийгээд тэр өдөр Мозамбикийн бичил уурхай нь ядуурлыг бууруулахад хэрхэн нөлөөлж байгаа талаарх туршлага, бичил уурхайн гар үйлдвэрлэлд олон нийтийн байгууллага, хувийн хэвшил, засгийн газрын хандлага, нөлөөллийн талаар илтгэлүүд тавигдаж, үдээс хойш нь сүүлийн 3 жилд өөрийн орондоо энэхүү чуулганыг зохион байгуулсан Мадагаскар, Монгол, Бразилын төлөөлөгчид илтгэл тавьсан.

Манайхаас ЭБЭХЯамны Уул уурхай хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга Б.Батхүү, CASM-н удирдах зөвлөлийн гишүүн Ч.Энхзаяа нар илтгэл тавилаа.

Дараагийн өдөр нь гурван чиглэлд хуваагдан салбар хуралдаанууд хийгдлээ Үүнд:

1. Бичил уурхайг гар аргаар олборлох тогтвортой орчин бий болгох
2. Бичил уурхай, том уурхай хоорондын харилцаа, хамтын ажиллагаа
3. Алтны уурхайд мөнгөн усыг хэрэглэж байгаа асуудал

Бид 1 дүгээр салбар хуралдаанд нь оролцсон ба энэ хуралдаанаар Ази, Африк, Латин америкт гар аргаар ашигт малтмал олборлох жижиг уурхайн хөгжлийн байдал, тэдгээрийн зохион байгуулалт, санхүүжилт, олборлосон бүтээгдэхүүнээ худалдан борлуулах талаар голчлон ярилцлаа.

Үдээс хойш дахин дөрвөн сэдвээр салбар хуралдаанууд явагдлаа. Үүнд:

1. Бичил уурхайд тулгарч буй хүндрэл, бэрхшээл
2. Бүтээгдэхүүний худалдаа, олон улсын стандарт, сертификат
3. Жендерийн асуудал

#### 4. Боловсрол, сургалт

Эдгээр салбар хуралдааны 2 дахь хэсэгт оролцлоо. Энд олборлосон бүтээгдэхүүнээ борлуулахын тулд хэрхэн маркетинг хийдэг, ОУ-н ямар стандартууд хэрэглэдэг, бүтээгдэхүүнд яаж сертификат олгодог тухай ярилцлаа. Харин нэг сонирхолтой зүйл нь энэ хуралдаан дээр Колумбид байдаг “Хариуцлагатай уул уурхайн төлөөх эвсэл”-ийн гүйцэтгэх захирал Кристина гэдэг хүн илтгэл тавьсан ба бид энэ хүнтэй тусгайлан уулзаж холбоо тогтоосон болно.

Гурав дахь өдөр буюу 11-нд Гар аргаар ашигт малтмал олборлох жижиг уурхайн нийгэмд, байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөлөл, хүний нөөцийн байдал, санхүүгийн тогтвортой хөгжлийн талаар илтгэл хэлэлцэгдээд үдээс хойш нь бичил уурхай дахь хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, хүний эрхийн талаар ярьж сайн дурынхны үндсэн зарчмыг тодорхойлж, дэлхийн дулаарлын нөлөөнийн талаар хэлэлцлээ.

Үдээс хойш нь CASM-н асуудлууд, түүнийг дараагийн 10 жилд хэрхэн хөгжүүлэх талаар, НҮБ-н тогтвортой хөгжлийн концептэй ажлаа хэрхэн уялдуулах талаар ярилцаж Африк, Ази, Хятадын CASM-н төлөөлөгчид үг хэллээ.

Үүгээр чуулганы эхний хэсэг дуусаж 12-нд Мапутоогоос 1200 км зайд байрлах Шинмой хотруу автобусаар аяллаа. Тэнд орон нутгийн “нинжа” нар хэрхэн алтыг баяжуулдаг, алтыг хэрхэн цэвэршүүлдэг талаарх үзүүлэх тоглолтыг үзлээ. Мөн тэндэхийн нинжа нарын алтны болон өнгөт металлын уурхайгаас гар аргаар ашигт малтмал олзворлож байгаа байдалтай танилцаж, Мозамбикийн үндэсний паркийг үзэж сонирхлоо. Ингээд 15 нд Шинмойгоос Мапуто руу яваад 16-ны өглөө мозамбикээс нутгийн зүг ниссэн.

CASM-ын удирдах зөвлөлийн гишүүдийн зураг, анкет, 9 дүгээр чуулганы хөтөлбөр, хуралд тавьсан илтгэлүүдийг бүрэн эхээр нь авч ирэн Санаачилгад өгсөн тул илтгэлийн талаар сонирхсон хүн байвал түүнийгээ лавлан судалж болно

Чуулганы бусад цагаар доорхи хүмүүстэй уулзаж, холбоо тогтоон нэрийн хуудсыг нь авсан ба эдгээрийг мөн Санаачилгын ажлын албанд өглөө. Үүнд:

1. Өмнөд африк дахь Стандарт банкны менежментын группын захирал Карин.М гэдэг хүнтэй уулзсан. Энэ хүн уул уурхайн хариуцлагын шалгуур үзүүлэлт боловсруулж байгааг их сонирхож байсан. Тэд уул уурхайн компаниудад зээл өгөхдөө тодорхой шалгуур үзүүлэлтийг хэрэглэдэг, түүнийг бидэнд өгч болно гээд холбоотой байхыг хүсэн. Мөн манай танилцуулгаас ХУУ- н зарчмуудыг үзээд дараахь зарим зөвлөгөө өглөө. Үүнд:
  - хууль дээдлэх гэдэгт олон стандартуудыг хир хэрэгжүүлж байгаагаар нэг шалгуур болно. Бэлэн стандартууд олон байгаа эдгээрийг том компаниудаар орчуулуулах хэрэгтэй. Мөн хууль дээдлэх гэдэгт тухайн компани бодлогын баримт бичигтээ Монгол улсын хуулийг мөрдөн ажиллана гэж заасан эсэх нь том шалгуур болно

- ирээдүйд хөрөнгө оруулна гэсэн зарчим байна. Энэ чинь гол нь уурхай хаасны дараа тэр орчимд ямар амьдрал байх талаар яаж төлөвлөсөн, бэлтгэл ажил нь хир явагдаж байгаа зэрэг олон үзүүлэлтээр хэмжигдэнэ Мөн орон нутгийн тариаланчидын бүтээгдэхүүн химийн бордоогүй чанар сайтай байдаг боловч үнэ хүрдэггүй. Гэтэл том уурхайн эзэд өөрсдийн зардлаар гадаадын өндөр үнэтэй эксперт хөлслөөд уг бүтээгдэхүүнийг чанартайг нотлуулаад, яаж брэнд болгох аргыг нь зааж өгөөд, олон улсад зарлаад байнгын зах зээлтэй болгож өгсөн туршлага байна
- орон нутгийн иргэдтэй харилцах аргачилал байдаг. Хятад хэл дээр бидэнд байгаа
- металлаа бүрэн авч чадаж байгаа эсэхээ хэмждэг багаж байгаа эсэх гэдэг бол нэг шалгуур үзүүлэлт юм
- гадаад дотоод ажилчидын харьцаа бол бас нэг чухал үзүүлэлт
- дэлхийн банкнаас боловсруулсан УУ-н салбарын санхүүжилтын зарчим байдаг. Үүнд санхүүжилтийн А, В, С зэрэглэл тогтоосон байдаг. Жишээ нь А зэрэглэлийн санхүүжилт авахын тулд төсөлдөө хөндлөнгийн үнэлгээ хийлгээд Вэб сайтдаа тавьсан байх шаардлага тавьдаг г.м. Үүнийг тэд орос хэл дээр хийсэн байж магад шүү
- Канадын УУ үйлдвэрлэгчдийн холбоо бий. Тэд илүү жижиг дунд үйлдвэрлэгчидэд хандсан байдаг
- Тогтвортой хөгжлийн төлөөх дэлхийн бизнесийн зөвлөл гэж байдаг. Тэнд та нарт хэрэгтэй мэдээлэл их бий Шаардлагатай файлыг чинь линкээр явуулж болно
- 

2. Хариуцлагатай уул уурхайн төлөөх эвслийн гүйцэтгэх захирал Кристинатай уулзсан. Тэр хүн Монголд ХУУС гэдэг байгууллага байдагт их олзуурхаж байсан. Мөн тэдний гаргасан бичил уурхайн стандартууд байгааг бидэнд өгч болно гэсэн. Тэд хариуцлагын төвшинг эдгээр стандартуудаа хир биелүүлж байгаагаар нь хэмжээд хариуцлагатайд нь “Ногоон алт” гэдэг таних тэмдэг олгодог юм байна. Мөн сертификат олгодог байна. Мөн хамтарч ажиллахыг хүссэн
3. Дэлхийн банкны уул уурхайн салбарын зээлийн шинжээч М.Ларсен гэдэг хүнтэй уулзсан. Энэ хүн мөн шалгуур үзүүлэлтийн талаар шаардлагатай мэдээллээ солилцоход бэлэн байна гэсэн
4. Вермонтын их сургуулийн доктор Салем.Н гэдэг хүнтэй танилцаж түүний удирддаг байгаль орчны талаарх ТББ-н олон улсын сүлжээнд хамрагдаж мэдээлэл авч байхаар тохиролцсон

5. Оксфордын их сургуулийн эрдэм шинжилгээний ажилтан Жемис Каст гэдэг хүнтэй уулзсан. Тэр хүн ТББ-дад зориулсан гарын авлага гаргаж байгаа ба энэ талаар нь хамтарч ажиллахаар тохиролцсон.

Энэ чуулганд оролцсоноор дараахь зүйлийг онцолж хэлмээр байна.

1. Үндсэн хуралдаанд Мозамбикийн эрдэс баялагийн яамны дэд сайд эхнээсээ аваад дуустал нь байнга оролцсон нь тэмдэглүүштэй санагдсан.
2. Нинжа нарыг гар аргаар ашигт малтмал олборлохыг хориглох биш үүнийг ядуурлыг бууруулах, ажилгүйдлийг багасгах чиглэлээр дэмжих хэрэгтэй юм байна гэдгийг ойлгосон
3. Африкт арслангууд том амьтныг унагаад том махыг нь иддэг дараа нь цөөвөр чоно, үнэг, хярс ээлж дараагаар өөрт тохирох жижиг хэсгийг иддэг, эцэст нь махчин шувууд ирж нэгч мах үлдэхээргүй болгож сэгийг мөлждөг. Түүнтэй адил замыг уул уурхайгаас ашигт малтмалд олборлох үйл ажиллагаа дамжиж болох юм байна гэдгийг ойлгосон. Том уурхайн эзэд орон нутагт ашиг муутай тусламж үзүүлснээс хэд хэдэн гар аргаар ашигт малтмал олборлох уурхайг хөл дээр нь босгож өгчихөөд явбал энэ тэдний ирээдүйг харсан хөрөнгө оруулалт болох юм байна. Манайх хоорондоо харьцах нь бүү хэл бие биетэйгээ дайсан мэт харьцдагийг больж болох юм байна
4. Аль ч улсад бичил уурхайд тулгарч буй бэрхшээлийг шийдвэрлэх асуудал нь адил дараахь агуулгатай байдаг юм байна. Үүнд:
  - Нинжа нар зохион байгуулалтанд орох
  - Үйл ажиллагаагаа эрхлэх санхүүжилтийн боломжтой болох
  - Ашигт малтмал олборлох, баяжуулах технологийн болон аюулгүй ажиллагааны сургалтын системтэй болох
  - Оролцогч талууд ойртон бие биенээ ойлгож, хамтран ажилладаг болох
  - Олборлосон бүтээгдэхүүнээ зах зээлд шударгаар борлуулах нөхцөлтэй болох
  - Үйл ажиллагаа нь бүгд албан ёсны болох

Эцэст нь энэ чуулганд оролцон мэдэж авсан мэдээллээ ашиглан удахгүй болох бичил уурхайн үндэсний чуулганы эрх зүйн орчны талаар тавих илтгэлд зориулж бичсэн бичил уурхайн хуулийн үзэл баримтлалд дараах санал оруулахаар боловсруулж ажлын хэсэгт өгсөн болно

## **Бичил уурхайн хуулийн төслийн үзэл баримтлалд оруулах миний санал**

### ***Монголд бичил уурхайн үйлдвэрлэл “нинжа” нь өнөө болон ирээдүйд үзүүлэх сайн нөлөө***

1. Ажилгүйчүүдийн тоо багасаж ялангуяа хөдөөгийн иргэд ажилтай болно. Ингэснээр
  - ядуурал багасан, иргэдийн амжиргааны түвшин дээшилнэ
  - ажилгүй сэлгүүцэн архидах, гэмт хэрэгт орооцолдох нь багасна
2. Ашигт малтмалыг гар аргаар олзворлох уул уурхайг хөгжүүлснээр ашигт малтмалийг хаягдал багатайгаар олборлох боломж нэмэгдэнэ
3. Байгалийн баялагийн өгөөжийг хүртэх боломжит хүмүүсийн тоо нэмэгдэнэ
4. Иргэдийн байгаль орчин, уул уурхайн талын мэдлэг боловсрол дээшилнэ
5. Бие даан ажил олж хийх боломжгүй болон иргэний эрхээ хасуулан хоригдогсад, архины эмчилгээнд хамрагдагсад дээрх ажлыг гүйцэтгэснээр улсаас төлүүлж байгаа зардлаа төлөхөөс гадна хүнийг санхүүгийн хувьд хохироосон хохирлоо барагдуулах, зарим нь гэр бүлдээ дэмжлэг үзүүлэх системийг бий болгох нэг боломж бий болно

### ***Монголд бичил уурхайн үйлдвэрлэл “нинжа” бий болсноос үүссэн сөрөг үзэгдэл болон түүний дутагдалтай тал***

1. Нөхөн сэргээлт хийгдэхгүй байгаа нь байгаль орчинд муугаар нөлөөлж байна
2. Гар аргаар ашигт малтмалыг олзворлоход ихэнхдээ усаар угаадаг тул усыг ихээр бохирдуулж байна
3. Бүх үйл ажиллагаа нь хууль зөрчиж байна. Өөрөөр хэлбэл албан ёсны бус байн гэсэн үг
4. Аюулгүй ажиллааны дүрэм, журам баримтлахгүйгээс осол, аварь ихээр гарч байна
5. Хүүхэд, эмэгтэйчүүдийг хүнд нөхцөлд ажиллуулж байна
6. Иргэдийн аюулгүй байдлыг хангах төрийн функцийг хэрэгжүүлэхгүй байна
7. Ямар нэгэн зохион байгуулалт байхгүй, тэнд ажиллагсад хүчтэй нь хүчгүйгээ дарамтлах маягтай амьдрал явагдаж байна
8. Тэдний үйл ажиллагаагаа эхлэх санхүүжилтийн механизм тодорхой бус
9. Ашигт малтмал олборлох технологи, аюулгүй ажиллагаа, байгалийн нөхөн сэргээлтийн талаарх мэдлэг дутмаг, буруу ойлголтууд газар авсан
10. Бүтээгдэхүүний чанар үнэлгээг тогтоодог газар байдаггүй тул олборлосон бүтээгдэхүүнээ бодит үнээр нь борлуулах механизм байхгүй, ченж нарт хямдаар зарж шударга худалдааны зарчим алдагдаж байна

**Иймд дээр дурдсан сайн үр нөлөөг хөгжүүлэх, сөрөг нөлөөллийг гаргахгүй байхын тулд эрх зүйн талаас зохицуулахын тулд зайлшгүй хууль гарах хэрэгтэй ба түүнд дараахь зохицуулалтыг заавал тусгах шаардлагатай байна**

1. Бичил уурхайг хориглох биш хөгжүүлэе. Үүний тулд эхлээд тодорхойлолтыг зөв гаргах хэрэгтэй. Тодорхойлолтод нь бичил уурхай гэдэг нэр таарахгүй, харин “гар аргаар ашигт малтмал олборлох үйлдвэрлэл” гэдэг нэр илүү зохимжтой байна. Учир нь энэ уул уурхайн үйлдвэрлэл нь ажиллах хүний тоогоор, ашиглагдах газар нутаг, олборлох бүтээгдэхүүний хэмжээгээр заавал жижиг байх албагүй юм Харин ашигт малтмалыг олборлох, баяжуулах үйл ажиллагааны ихэнх нь гар аргаар явагддаг, зарим дамжлагад нь бага хүчин чадалтай, жижиг оврын техник хэрэглэж байгаагаараа том уул уурхайгаас ялгагдаж байна. Энэ тодорхойлолтыг бид сайн гаргаж өгснөөр одоогийн уурхайнууд жижиг уурхайн нэрээр ажиллах нөхцлийг хаах юм
2. Тэдний олборлосон ашигт малтмалыг нь бодит үнээр нь борлогдох боломжийг бий болгох зохицуулалтыг хуульд тусгах. Үүнд:
  - алт болон үнэд эдлэлийн чанар, тоо хэмжээг тогтоодог байгууллагыг орон нутагт бий болгох, тэдгээрийн эрх үүргийг тогтоож өгөх
  - алт болон үнэд эдлэлийг худалдаж авдаг байгууллагыг орон нутагт бий болгох, тэдгээрийн эрх үүргийг тогтоож өгөх
3. Бүртгэл, зөвшөөрөл лицензийн асуудлыг хуульд зөвөөр тусгах Үүнд:
  - бүртгэгдээгүй нөхөрлөл гэдэг хууль зөрчсөн нэгжийг бий болгож болохгүй л байх
  - хайгуулийн лиценз олгох асуудал байхгүйг хуульд тодорхой тусгах
  - ашиглалтын лиценз, эсвэл орон нутгийн эрхийн бичгийг олгох бөгөөд түүнд олгох ашигт малтмалын төрөл, олборлолтын төвшин, үе шатыг нарийн тодорхойлох асуудлыг тусгасан байх.
  - зөвхөн гар аргаар олборлох болон зарим төвшинд /нүүрсний уурхай/ нь заавал гар аргаар ашигт малтмалыг олборлох болон зарим хэсгийг нь гар аргаар олборлох шаардлагатай ордын жагсаалт, үзүүлэлтийг батлахыг хуульчлах.
4. Гар аргаар ашигт малтмал олборлох технологи, аюулгүй ажиллагаа, байгалийн нөхөн сэргээлтийн талаарх сургалтын системийг тухайн орон нутагт байгаа ашиглаж болох ордоос нь хамааруулан бий болгох зохицуулалтыг хийх
5. Үйлдвэржсэн том уурхай нь гар ажиллагаатай уурхайтай хэрхэн хамтарч ажиллах, тэдний харилцаа, түншлэлийн арга замуудыг тусгах /өнөөдөр том уурхай нинжа нараас айдаг, тэгвэл хамтарч ажилладаг болгох боломжтой/

6. Гар аргаар ашигт малтмал олборлоход баримтлах ямар заавар, аргачилал, стандартуудыг боловсруулж мөрдөх асуудлыг хуульд тусгах
7. Байгаль орчныг нөхөн сэргээгүй, аваарь осол гаргаж хүний амь эрсдүүлсэн болон бусад асуудлаар хууль зөрчсөн нөхцөлд тооцох хариуцлагыг тооцох, гарахаас урьдчилан сэргийлэх зохицуулалтыг нарийн тусгах
8. Уул уурхай эрхлэгчдээс орон нутагт үзүүлэх тусламжийг тэнд бичил уурхайгаар ажлын байр бий болгох боломжид хандуулах асуудлыг тусгах

Г.БАТСАЙХАН

2009-09-28.